

**ӨЛЗИЙ ДУНДГОВЬ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2026 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 0/

Улаанбаатар хот

Г “ӨЛЗИЙ ДУНДГОВЬ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит 7
хурлыг зарлан хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх заалт, 60 дугаар зүйлийн 60.1 дахь заалт, 62 дугаар зүйлийн 62.1 дахь заалтууд, 2024 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын тэмдэглэл, Санхүүгийн Зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 377 дугаар тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх” журмыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 18.00 цагт Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 5 дугаар хороо, Ялалтын талбай “Оранж плаза” 903 тоотод хуралдуулахаар тогтоосугай.

2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар доор дурьдсан асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай.

- Компанийн 2023 оны үйл ажилагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлт;
- Ногдол ашиг хувиарлахгүй талаар ТУЗ гаргасан шийдвэрийг танилцуулах;
- ТУЗ-ийн дарга, гишүүдийг сонгох
- Компанийн үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах
- Их хэмжээний хэлцэл батлах
- Компанийн оноосон нэр өөрчлөх
- Компанийн үйл ажиллагааны чиглэл өөрчлөх
- Компанийн дүрэм өөрчлөх
- Бусад

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөр тогтоосугай.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тухай зарыг өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдөр тутмын сонин болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр, 2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр дахин мэдээлэх,

Монголын хөрөнгийн биржийн сайтад тавих, брокерийн компанид хүргүүлэх зэргээр хувьцаа эзэмшигчдэд мэдэгдсүгэй.

4. Хурлын зар өгөхтэй холбоотой зардлыг хурал зохион байгуулах комиссын дарга /Э.Мөнхзул/-д гаргаж өгөхийг компанийн санхүүд даалгасугай.

5. Ээлжит хурлыг хуралдуулахтай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь Хавсралт 1-д заасан бичиг баримтыг БДК-иудаас авч танилцах эрхтэй болохыг дурьдсугай.

6. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс энэхүү хурлаар хэлэлцэх асуудлаар саналын хуудсаар санал авах “саналын хуудас”-ны агуулгыг хавсралт 2-д зааснаар баталсугай.

7. Компанийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх асуудлаар санал авах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 10.00 цагаар тасалбар болгосугай.

8. Хурал удирдах, хурал зохион байгуулах, тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

- | | |
|------------------|---------------------------------------|
| • Ж.Жаргалсайхан | Хурлын дарга |
| • Э.Мөнхзул | Хурал зохион байгуулах комиссын дарга |
| • Д.Мөнхтөмөр | тооллогын комиссын дарга |
| • Ю.Бадамзул | гишүүн |
| • Г.Болор-Эрдэнэ | гишүүн |

9. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга, хурлаас гарах шийдвэрийн төслийг тогтоосон хугацаанд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комиссд даалгасугай.

10. Хурал хуралдуулах тухай тогтоолыг гаргаснаас хойш 3 хоногийн дотор хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэлийг Хавсралт 3-д заасан маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргэхийг хурал зохион байгуулах комиссын дарга /Э.Мөнхзул/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

/Т.Оюунбаатар/

“Өлзий дундговь” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2026 оны 03 дугаар сарын 21-ны өдрийн О/ тоот
тогтоолын Хавсралт №01

“ӨЛЗИЙ ДУНДГОВЬ” ХК-ИЙН

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД ОРОЛЦОХ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД ТАНИЛЦУУЛАХ БАРИМТ БИЧИГ**

“ӨЛЗИЙ ДУНДГОВЬ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах болсонтой холбогдуулан тус хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд дараах бичиг баримтыг танилцуулна.

- Компанийн 2025 оны үйл ажилагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлт;
- Ногдол ашиг хувиарлахгүй талаар ТУЗ гаргасан шийдвэрийг танилцуулах;
- ТУЗ-ийн дарга, гишүүдийг сонгох
- Компанийн үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах
- Их хэмжээний хэлцэл батлах
- Компанийн оноосон нэр өөрчлөх
- Компанийн үйл ажиллагааны чиглэл өөрчлөх
- Компанийн дүрэм өөрчлөх